

Нэгдсэн хандалтын орчинд нэвтрэх заавар

Гарчиг


Танилцуулга	2
Нэвтрэх	3
I. SISI эрхээр нэвтрэх	3
Алхам 2.а Утасны дугаар ашиглан баталгаажуулалт хийх	4
Алхам 2.б Authenticator буюу хамгаалалтын аппликэйшин ашиглан нэвтрэх	6
II. Цахим шуудангаар нэвтрэх	11
Нууц үг солих	12

Танилцуулга

Нэгдсэн хандалтын орчин нь МУИС-ийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системүүдэд нэг орчноос хандах, нэвтрэх хандалтыг баталгаажуулах зориулалтай систем юм.

Нэгдсэн хандалтын орчны системд SISI мэдээллийн системийн нэвтрэх эрх болон МУИС-ийн албан ёсны ...@num.edu.mn ,...@stud.num.edu.mn цахим хаягийн нэвтрэлтийг ашиглан нэвтэрнэ. Мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах үүднээс нэвтэрсэн хэрэглэгчийн эрхийг давхар баталгаажуулах otp буюу бүртгэлтэй гар утасны дугаарт баталгаажуулах код илгээж баталгаажуулах, authenticator буюу ухаалаг гар утасны аппликейшн ашиглан баталгаажуулах боломжийг агуулсан.

Нэгдсэн хандалтын орчин нь хэрэглэгчийн ашиглах эрхтэй мэдээллийн системүүдийг багтаасан үндсэн хэсэг, системийн хандалтын түүх харах, нэгдсэн хандалтын тохиргоо хийх, мэдээ мэдээлэл, хичээлийн жилийн календарчилсан төлөвлөгөө гэсэн дэд хэсгүүдтэй.



Нэвтрэх

Нэгдсэн хандалтын орчинд нэвтрэх дараах хоёр арга байна.

1. SISI мэдээллийн системийн эрхээр нэвтрэх
2. МУИС-ийн албан ёсны ...@num.edu.mn эсвэл ...@stud.num.edu.mn цахим

шуудан ашиглан нэвтрэх



Нэвтрэх зааврыг харгалзах бүлгээс сонгон харна уу.

I. SISI эрхээр нэвтрэх

SISI мэдээллийн системийн эрхээр нэвтрэх алхамууд:

Алхам 1.

Системд нэвтрэхийн тулд SISI мэдээллийн системд нэвтэрдэг хэрэглэгчийн нэр, нууц үг оруулан **Нэвтрэх** товч дарна.

The screenshot shows the login interface for the SISI system. At the top is the logo of the Mongolian State University (МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ). Below the logo are two tabs: "SISI эрхээр" (selected) and "Цахим шуудангаар". The login form includes:

- A text input field for "Хэрэглэгчийн нэр" (Username) with a callout: "Хэрэглэгчийн нэр оруулах".
- A password input field for "Нууц үг" (Password) with a callout: "Нууц үгийг оруулах".
- A checkbox for "Эрх сануулах" (Remember me) with a callout: "Эрх сануулснаар дахин нэр, нууц үгийг оруулах шаардлагагүй болно.".
- A "Нууц үг сэргээх" (Forgot password) link.
- A large blue "Нэвтрэх" (Login) button.



Алхам 2.

Нэвтэрсэн хэрэглэгчийн эрхийг баталгаажуулахын тулд та бүртгэлтэй **Утасны дугаар** эсвэл **Authenticator аппликэйшн** гэсэн аргуудаас аль нэгийг нь сонгон баталгаажуулалт хийнэ.

Баталгаажуулалт

1 — 2

Нэг удаагийн код авах хэлбэрээ сонгоно уу.

 Мессеж Та утсаа бүртгүүлнэ үү.	<input type="radio"/>	Бүртгэлтэй утасны дугаарт баталгаажуулах код авах
 Authenticator Microsoft, Google	<input checked="" type="radio"/>	Authenticator аппаар баталгаажуулах код авах




Баталгаажуулалт хийх зааврыг харгалзах бүлгээс сонгон харна уу.


Алхам 2.а **Утасны дугаар ашиглан баталгаажуулалт хийх**

SISi мэдээллийн системд бүртгэлтэй гар утсанд баталгаажуулах код илгээгдэх бөгөөд мессежээр ирсэн кодыг оруулан баталгаажуулна.

- Уг үйлчилгээг ашиглахын **Баталгаажуулалт** хэсгээс **Мессеж** гэсэн сонголтийг хийж сонгон **Дараах** товчийг дарж үргэлжлүүлнэ.



- Бүртгэлтэй гар утсанд 6 орон бүхий баталгаажуулах код ирэх бөгөөд тухайн кодыг оруулан **Дараах** товчийг дарснаар системд нэвтэрнэ.



- Амжилттай идэвхжүүлэлт хийгдсэнээр нэгдсэн хандалтын орчны нүүр хэсэгт шилжинэ.

Санамж:

- Хэрвээ системд бүртгэлтэй байгаа дугаараа солиулах болон шинээр бүртгүүлэх тохиолдолд багш ажилчид ЗХНГ-т, Суралцагчид Элсэлт бүртгэлийн хэлтэст хандан утасны дугаараа бүртгүүлэх болон солиулах боломжтой.

Алхам 2.6 Authenticator буюу хамгаалалтын аппликэйшин ашиглан нэвтрэх

Authenticator гэдэг нь ухаалаг гар утсанд суурилуулсан хүсэлт бүрт 6-8 оронтой тоон кодыг гаргадаг хамгаалалтын аппликэйшн юм. Authenticator аппликэйшнаас ирсэн кодыг баталгаажуулах хэсэг оруулан баталгаажуулна хийнэ.

Уг үйлчилгээ ашиглахын тулд дараах үйлдлийг хийнэ.


- 1 шат. Authenticator аппликэйшн суулгах
- 2 шат. Authenticator идэвхжүүлэх буюу бүртгүүлэх
- 3 шат. Нэвтрэх үеийн баталгаажуулалтын код авах



Үйлдлүүдийн зааврыг харгалзах бүлгээс сонгон харна уу.

1-р шат Authenticator аппликэйшин суулгах заавар

- Гар утсандаа **Google Authenticator** эсвэл **Microsoft Authenticator** аппликэйшний **'аль нэг'**-ийг татан суулгана. Android үйлдлийн системийн утастай бол **Play Store**, iOS үйлдлийн системийн утастай бол **App Store** - с Microsoft Authenticator эсвэл Google Authenticator гэж бичиж хайгаад татаж суулгана. Та аль аппликэйшн-г татсанаас хамаарч дараах байдалтай харагдана.



2-р шат Authenticator идэвхжүүлэх буюу бүртгүүлэх


- Authenticator аппликэйшн нээж бүртгүүлэх хэсэг буюу хэрэглэгч нэмэх хэсгийг сонгоно.



- Нэгдсэн хандалтын орчны **Баталгаажуулалт** хэсгээс **Authenticator** гэсэн сонголтыг хийж сонгон **Дараах** товчийг дарж үргэлжлүүлнэ.




- Authenticator идэвхжүүлэлт хийх талбар харагдана.



- Идэвхжүүлэлтийг системээс өгөгдсөн **manual setup code** ашиглах идэвхжүүлэлт хийнэ. Үүний тулд системээс өгөгдсөн кодыг Authenticator аппликэйшний талбарт бичиж оруулах,


эсвэл **QR** кодыг *Google Authenticator* татсан бол **Scan a QR code** дээр, *Microsoft Authenticator* татсан бол **Work or school account** эсвэл **Other** дээр даран уншуулна.



- Manual setup code эсвэл QR код уншуулснаар Authenticator аппликэйшнаас 6 оронтой идэвхжүүлэх код үүсэх бөгөөд уг кодыг баталгаажуулалт цонхны 4 дугаартай хэсэгт оруулан **Баталгаажуулах** товч дээр дарна.

The image shows two screenshots of authentication apps. On the left is Google Authenticator, displaying a 6-digit code '211 321' for account 'NUM'. On the right is Microsoft Authenticator, displaying a 6-digit code '730 436' for account 'NUM'. Below these is a 'Баталгаажуулалт' (Setup) screen with a two-step progress indicator. Step 1 shows a 'Manual setup code' (M1SDG0DGGFRTCLLCGI2DMLIU3M3TILLBG5QTKLIQGITGENLEMU2WGMLCGE) with a callout: 'Authenticator апп-д нэвтрэн Manual setup code-г оруулан баталгаажуулах'. Step 2 shows a QR code with a callout: 'Authenticator апп-д нэвтрэн QR код-г уншуулна'. Below the QR code is a text input field with a callout: 'Authenticator дээр ирсэн 6 оронтой баталгаажуулах кодыг оруулна'. At the bottom are back and 'Баталгаажуулах' (Setup) buttons. A large blue arrow points from the Google Authenticator code to the input field in the setup screen.

- Амжилттай идэвхжүүлэлт хийгдсэнээр нэгдсэн хандалтын орчны нүүр хэсэгт шилжинэ.


 Зөвхөн эхний удаа нэвтэрч орохын тулд QR код ашиглан өөрийгөө амжилттай таниулан баталгаажуулсны дараа дахин нэвтрэх үед шууд Authenticator аппликэйшнд дээр хамгийн сүүлд үүссэн 6-н оронтой кодыг оруулан нэвтэрч орно.

3-р шат Нэвтрэх үеийн баталгаажуулалтын код авах

Authenticator идэвхжүүлэн таниулсан тохиолдолд дараагийн нэвтрэлтээс эхлэн Authenticator аппликэйшнд үүсэх 6 оронтой кодыг оруулан нэвтрэнэ.

- Нэгдсэн хандалтын орчны **Баталгаажуулалт** хэсгээс **Authenticator** гэсэн сонголтыг хийж сонгон **Дараах** товчийг дарж үргэлжлүүлнэ.

Баталгаажуулалт



- Authenticator аппликэйшнд гарч ирсэн 6 оронтой кодыг оруулан **Дараах** товчийг дарснаар системд нэвтрэнэ.

Баталгаажуулалт




- Амжилттай идэвхжүүлэлт хийгдсэнээр нэгдсэн хандалтын орчны нүүр хэсэгт шилжинэ.


II. Цахим шуудангаар нэвтрэх

SISi мэдээллийн системийн эрхээр нэвтрэх алхамууд:

- Тухайн хөтөчийг ашиглан өөрийн албан ёсны цахим шуудангаар **нэвтэрсэн** тохиолдолд:



- Тухайн хөтөчийг ашиглан өөрийн албан ёсны цахим шуудангаар **нэвтрээгүй** тохиолдолд:



- Амжилттай идэвхжүүлэлт хийгдсэнээр нэгдсэн хандалтын орчны нүүр хэсэгт шилжинэ.

Нууц үг солих

- Нууц үгээ мартсан тохиолдолд **Нууц үг сэргээх** гэсэн товч дээр дарна.

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

SIS эрхээр Цахим шуудангаар

Хэрэглэгчийн нэр

Нууц үг

Эрх сануулах Нууц үг сэргээх >

Дарах

Нэвтрэх

- Нууц үг сэргээх товч дарсны дараа SIS мэдээллийн системийн хэрэглэгчийн нэр болон цахим шууданг оруулан **Сэргээх** гэсэн товч дээр дарна.

SIS мэдээллийн системийн нууц үг сэргээх

Та SIS мэдээллийн системийн хэрэглэгчийн нэр болон SIS мэдээллийн системд бүртгэлтэй МУИС-ийн албан ёсны ...@num.edu.mn эсвэл ...@stud.num.edu.mn цахим шуудангийн хаягаа оруулан Сэргээх товч дээр дарна уу.

Хэрэглэгчийн нэр

Цахим шууданг

i'm not a robot

Дарах


Сэргээх

Дарах

Амжилттай илгээлээ.

Та цахим шуудангийн хаягаа 24 цагийн дотор шалган нууц үгээ солино уу. Зарим тохиолдолд цахим шуудан Spam, Junk-д орсон байж болзошгүйг анхаарна уу!

- Хэрвээ цахим шуудан амжилттай илгээгдсэн бол амжилттай илгээсэн тухай хариу ирэх бөгөөд таны цахим шууданд дараах зурвас очих болно. Цахим шууданг шалган [ЭНЭ](#) гэсэн холбоос дээр дарж нууц үгийг солино.



- Дараах хэсэгт шинэ нууцыг оруулан **Өөрчлөх** товч дээр дарна.

Нууц үг өөрчлөх

Шинэ нууц үг нь 8 аас дээш урттай тоо болон латин үсэг агуулсан байх ёстой.

Шинэ нууц үг

Шинэ нууц үг давт

Өөрчлөх

Таны нууц үг амжилттай солигдлоо. Та [энд](#) дарж системд нэвтэрнэ үү!

Санамж:

- Цахим шуудан хаяг бичих хэсэгт бичсэн хаяг нь заавал системд бүртгээгдсэн тохиолдолд цахим шуудан илгээгдэх бөгөөд системд бүртгээгдсэн хаяг таны бичсэн хаяг зөрсөн тохиолдолд цахим шуудан илгээгдэхгүй болохыг анхаарна уу.
- Хэрвээ системд ямар хаяг бүртгэлтэй байгаагаа мэдэхгүй бол салбар Элсэлт бүртгэлийн хэлтэст хандан и-мэйлээ нэмүүлэх болон солиулах боломжтой.